

ӨДГӨЙНХ 197X

ЯПОН-МОНГОЛЫН СУРГАЛТЫН ЭМНЭЛЭГ
МОНГОЛД ЭМЧЛЭХ БОЛОМЖГҮЙ 26 ӨВЧНИЙГ ЭМЧИЛНЭ

У.САРАНГЭРЭЭ

Япон Улсын Засгийн газрын 174 тэрбум 400 сая төгрөгийн буцалтгүй тусламжаар баригдаж байгаа Япон-Монголын сургалтын эмнэлэг ажиллагаатад ороход бэлэн болжээ. Тус эмнэлгийн үйл ажиллагааг сурвалжлахаар Японы Эмнэлгийн яамны ажилчид болон сэтгүүлчид Баянзүрх дүүргийг зориллоо. Тэнд биднийг Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн удирдлагууд болон Японы "Жайка" байгууллагын төлөөллүүд хүлээж байлаа. Монголд үзэж байгаагүй орчин үеийн загвараар баригдсан цоо шинэ будаг нь хангалсан эмнэлгийн үүдээр ороход бидэнд улаан өмсүүлэн хоёр давхрын хурлын танхим руу хөтөлсөө. Хурлын танхимд бид гутлаа тайлж, оймстойгоо орох нь Япон Улсад хүрээд ирэх үү гэх мэдээллийг төрүүлж байв.

Япон-Монголын сургалтын эмнэлгийн талаар АШУУИС-ийн захирал Ж.Цолмон болон "Жайка"-гийн Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга Тамүра Эрико, Япон-Монголын сургалтын эмнэлгийн менежеринтэсгийн дэд удирдагч Абэ Хироши, "Azusa" барилгын компанийн зөвлөх Миёоши Оно нар мэдээлэл өгсөн юм. Япон-Монголын сургалтын эмнэлэг нь гуравдугаар шатлалын өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх юм байна. Тодруулбал, 104 ортой байх бөгөөд Монголд эмчлэгдэх боломжгүй зурх, судасны өвчин эмгэг, тархины өвчин эмгэг, хавдэр зэрэг 26 өвчнийг эмчлэх боломжтой болох гэнэ. Энэ талаар АШУУИС-ийн захирал Ж.Цолмон "Япон-Монголын сургалтын эмнэлгийн үйл ажиллагаа гурван үндсэн төслөөс бүрджээ. Нэгдүгээрт, барилга байгууламжийн төсөл. Эмнэлгийн барилга 2016 оноос эхлэн баригдсан. Улсын комисс өнөөдөрөөс эхлэн сургалтын эмнэлэг дээр ажиллана. Дөрөвдүгээр сарын 1-нд барилгаа хүлээж авахад төлөөлөл ажиллаж байна. Ингэснээр бид дараагийн төсөл болох менежеринтэсийн төслөө эхлүүлнэ. Манай иргэд гадаадад гэрч эмнэлгийн тусламж үйлчилгээг авдаг. Энэ урсгалыг эх орондоо тодорхой хэмжээнд зогсоох боломжийг бий болгох ач холбогдолтой. Дэлхий дээр хэрэгжиж байгаа шинэ техник, технологийг эх орондоо нутагшуулах үйл ажиллагааг сургалтын эмнэлэгт хэрэгжүүлэх юм. Төслийн шугамаар 1400 эмч эмнэлгийн ажиллагсдыг сургаж байна. Мөн Япон улсад 66 эрдэмтэн, багш нар сургалтад хамрагдаж мэдлэг, мэдээлэлтэй болоод байна. Японоос менежеринтэсийн багш зургаан ирсэн. Тэд бидэнд эмнэлгийн хаалгаар орж цооноо гарах хүртэл Японы эмнэлгүүд нийт зарчмын баримтлалд тэр болсныг зургаан




нь дагуу зааж өгөх юм. Зургадугаар сарын 17-нд эмнэлэг нээгдэж эхний байдлаар амбулаторийн үйлчилгээ эхэлнэ. 40 орчим кабинет, хоёртөө, 16 тасаг, 16 албатайгаар үйл ажиллагаа явуулна. АШУУИС-ийн эрдэмтэн багш нар энэ эмнэлэгт ажиллана. Монголд анх удаа их сургуулийн эмнэлэг байгуулагдсан учраас эрх зүйн талаас бархшээл бий. Эрүүл мэндийн тухай хуульд их сургуулийн эмнэлэг хэрхэн ажиллах вэ гэдэг тогтолцоо бий болгох тал дээр ажиллах шаардлага байгаа. Наймдугаар сарын 1-нээс эхлэн хэвтэн эмчлүүлэх тасгаа ажиллуулна. Бүх тасгууд нээгдэж үйл ажиллагаагаа эхлүүлснээр 2019 оны арванхоёрдугаар сар гэхэд эмнэлэг бүрэн хүчин чадлаар ажиллана. Одоогоор Японы талаас 360 гаруй нэр төрлийн тоног төхөөрөмжийг энэ эмнэлэгт суурилуулаад байна. Монгол Улсад байхгүй орчин үеийн тоног төхөөрөмжүүд ирсэн. MRI, CT, 160 зүслэгтэй компьютер томограф, ангиограф зэрэг хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж суурилагдсан байгаа. Бүрэн автомат лабораторийн анализатор суурилагдсан. Монголын талаас 2.7 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Одоо гаднах тохижилтын ажил үлдээд байна" гэлээ.

13.5 ТЭРБУМ ИЕНИЙН
ӨРТӨГ БҮХИЙ ТОНОГ,
ТӨХӨӨРӨМЖ
СУУРИЛУУЛЖЭЭ

Монгол-Японы сургалтын эмнэлгийн барилгыг Японы 50 жилийн түүхтэй "Canto" констракшн барьж байгаа бөгөөд зөвлөхөөр нь "Azusa" барилгын компани, туслан гүйцэтгэгчээр нь "Junson" компани гардан ажиллажээ. Тус барилга амбулатори, сургалтын хэсэг, хэвтэн эмчлүүлэх тасаг гэсэн хэсгээс бүрджээ. "Azusa" барилгын компанийн зөвлөх Миёоши Оно сургалтын эмнэлгийн барилгын бүтэц зохион байгуулалтыг танилцуулсан юм. Тэрбээр "Бид Цагаан сарын баяраар амрагчид сургалтын ажлыг эрчимтэй явуулсан. Төсөл анхны төлөвлөсөн хугацаанаасаа хоцорсон. Цаг агаарын хүндрэлтэй

нөхцөл байдал, хөрш орнуудаас барилгын материал оруулж ирэх зэрэг дээр цаг их алдсан. Бид барилгыг хүлээлгэж өгөхөө 270 төрлийн эд хогшлыг дагалдуулах болно. Ойролцоогоор 13.6 тэрбум иенийн өртөг бүхий

автомат бидэ суурилуулсан нь Эрүүл ахуйг бодож хийсэн шийдэл юм. Ажилчид болон эмчлүүлэгчдийн тав тухыг хангах үүднээс тухайн хэсгүүдэд шүршүүрийн өрөөнүүдийг төлөөлж хийсэн. Өрөөнүүдэд Монголд тэр бүр харагдаад байдаггүй



төхөөрөмж суурилагддаг байгаа. Дөрөвдүгээр сарын 8-нд сүүлийн тоног төхөөрөмжүүдийн угсралт, суурилуулалтын ажил дуусаа. Эүүн тал руугаа явж буйрч бэлдэж, хажуу талын ихдэригт хүрээлэнг төлгөдхүйг том цонх хийсэн. Хөгжлийн бүрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөө төлөөлж хийсэн. Суутгууруудад

гүйдэг хаалга хийн өгсөн. Ажлын төрлөөс шалтгаалан байгууламжад 3-10 жилийн баталгаат хугацаа өгч байгаа. Навц материалуудыг өгөх болно. Хөшиг, ханан цилта, будаг эмүлс, хаалга цоонохыг тохиоллол зэрэг хэрэгслүүдийг нөөцөд хангалттай бэлдэж өгч байна" гэсэн юм. Харин Япон-Монголын сургалтын эмнэлгийн менежеринтэсийн

төслийн дэд удирдагч Абэ Хироши "Бид энэ эмнэлгийг дөрвөн үр дүнд хүрэхийг зорин ажиллана. Эмнэлгийн менежеринтэс зохистой байх, өвчтөн төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээг нэвтрүүлэх, шинэ дэвшилтад эмнэлгийн тусламж үйлчилгээг нэвтрүүлэх, өндөр түвшний яаралтай тусламжийн бүтэц зохион байгуулалтыг бүрдүүлэх гэсэн гол үр дүнг гаргах юм. Сургалтын эмнэлэг нь гурван гол онцлогтой. Нэгдүгээрт, Монголд хамгийн анхны сургалтын эмнэлэг болохынхоо хувьд "эмнэлзүй", "боловсрол", "судалгаа" гэсэн гурван гол үүргийг гүйцэтгэнэ. Монголын анагаахын салбарыг цаашид авч явах ирээдүйн эмнэлгийн ажилтнуудын хүний нөөцийг бэлдэх, сургах, боловсруулах ажлаа давхар хийнэ. Хажуугаар нь давхар судалгааны ажлуудыг гүйцэтгэдг явах юм. Бас нэг онцлог нь Япон маягийн эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх юм. Японы талаас маш итгэлтэйгээр хэлж чадах зүйл бол эмнэлэгт ажиллаж эмч, сувилагч, ажилтнууд багаар эмнэлгийн тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэх юм. Манай эмнэлэгт хүмүүс үйлчилүүлд "Япон бил үү, Монгол бил үү" гэж эндүүрэхээр орчин нөхцөлийг бүрдүүлэхээр зорин ажиллаж байна" хэмээсэн юм.

Япон-Монголын сургалтын эмнэлгийн талаарх мэдээллийн дараа "Azusa" барилгын компанийн зөвлөх Миёоши Оно сургалтын эмнэлгийн барилгатай биднийг



танилцууллаа. Үнэхээр л япон хүний гараар бүтсэн тус эмнэлгийн барилга маш чанартай нь мэдэгдэж байв. Хүүхдийн тасаг л гэхэд тусгай зориулалтын ор, хана, цонх зэргийг нь шийдэж өгчээ. Хөгжлийн бархшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөө, тусгай зориулалтын шүршүүрийн өрөө гал тогоо зэрэг хүнд хэрэгцээтэй бүх зүйлийг тав тухтай байдлаар шийдэж өгсөн нь сайхан санагдаж байлаа.